



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 17 өдөр

Дугаар А/501

Булган сум

**“Хариуцлагатай малчин-Эрүүл мал”
аян зохион байгуулах тухай**

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга, ерөнхий малын эмчийн 2024 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 01 тоот албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Засаг даргатай нартай байгуулсан гэрээнд заасан мал эмнэлгийн төлөвлөгөөт арга хэмжээг хэрэгжүүлэх, малын амьтныг шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд “ХАРИУЦЛАГАТАЙ МАЛЧИН-ЭРҮҮЛ МАЛ” аяныг аймгийн хэмжээнд 2024 оны 07 дугаар сарын 16-наас 08 дугаар сарын 15-ны өдрүүдэд, 2024 оны 09 дүгээр сарын 15-наас 10 дугаар сарын 15-ны өдрүүдэд хоёр үе шаттай тус тус зохион байгуулсугай.

2. Сумын мал эмнэлэг, малын эмч нарыг мэргэжил арга зүй, удирдлагаар хангаж, явцын хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Г.Одсүрэн), мал угаалгын ажлыг орон нутагт зохион байгуулж хүн хүч, машин техник, бусад шаардлагатай зүйлээр хангаж, малчид, багийн дарга нарыг үүрэгжүүлэн ажиллахыг сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Мал угаалгын ажлын арга хэмжээг зохион байгуулсан дүн мэдээг нэгтгэн 2024 оны 10 дугаар сарын 31-ны өдрийн дотор аймгийн Засаг даргын удирдлагын багийн хуралд танилцуулахыг Мал эмнэлгийн газар (Г.Одсүрэн)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



В.АРИУН-ЭРДЭНЭ

6324010867